

Т. Баасанчурэн

СЭТГҮҮЛЧИЙН ЁС ЗҮЙН ОНОЛ-ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Ийм сэдвээр өнөөдрийн эрдэм шинжилгээний бага хурал дээр намайг ярихыг хүссэн юм. Сэтгүүлчийн ёс зүйн тухай асуудал нь онолын гэхээсээ илүү практикийн тухай ойлголт юм шиг санагддаг. Тэгсэн атлаа энэ талаар нэгдмэл нэг ойлголт дэг жаяг Монголд тогтох хараахан чадаагүй байгаа юм. Үүний үндэс шалтгааныг сонирхон судлаад ирэхээр сэтгүүл зүйнхээ онолтой өөрийн эрхгүй холбогдож, түүнээс үүдэл гаралтай болох нь мэдрэгдээд ирдэг юм. Тийм болохоор сэтгүүлч гэж хэн бэ, ийм мэргэжил хэзээ хэрхэн яаж үүсч хөгжсөн юм бэ гэсэн асуулт өөрийн эрхгүй гарч ирдэг. Үүнд: сэтгүүлч хэмээгч нь хүн төрөлхтөний ууган, анхдагч мэргэжлүүдийн нэг гэж хариулмаар байна. Сэтгүүл зүйн шинжлэх ухааны элементүүд хүний нийгмийн хөгжил дэвшилтэй хамт үүсч хөгжин гүнзгийрсэн байдаг.

Анх үүсэн төлөвшихөөсөө өхлээд чөлөөт байдлын төлөө тэмцэж өхэлсэн цөөхөн мэргэжлийн нэг нь сэтгүүл зүй юм гэдгийг онцгойлж хэлмээр байна. Монголд гэхэд бүр 1913 оны “Шинэ толь хэмээх сонин бичиг” сониноос үүсэлтэй байх жишээтэй.

Сэтгүүл зүй нэгэnt шинжлэх ухаан юм болохоор өөрийн үндсэн зарчим ба үүрэгтэй байдгийг та бүгд сайн мэднэ. Сэтгүүл зүйг судлаачдын олонхийн санал бодлоор эдгээр үндсэн зарчимд:

Нэгд: үнэн бөгөөд бодитой байх зарчим; хоёрт: шуурхай бөгөөд хүртээмжтэй байх зарчим; гуравт: ил тод бөгөөд олон ургальч байх зарчим; дөрөвт: хүнлэг бөгөөд энэрэнгүй байх зарчим; тавд: олон нийтэч бөгөөд амьдралтай нягт холбоотой байх зарчим; зургаад: шинжлэх ухааны үндэстэй байх зарчим багтаж байна гэж өнөөдөр үзэж байна.

Энэ нь сэтгүүл зүйн хувьд стратеги зорилтыг хэрэгжүүлэх арга замыг заагч луужин болж өгнө. Аль ч сонин, сэтгүүл, радио, телевиз, мэдээллийн агентлагийн хувьд баримтлах үндсэн чиг шугам нь эдгээр зарчим мөн.

Сэтгүүл зүйн үндсэн зарчмуудаас түүний үндсэн үүргүүд шууд ургаж гарна. Энэ бол өдөр тутам мөрдлөг болгож байвал зохильтой үйл ажиллагааны чиглэл гэсэн үг. Сэтгүүл зүйд үндсэн долоон үүрэг үйлчилж байдаг гэж сэтгүүл зүйн эрдэмтэд, судлаачид үзэж байна. Үүнд:

Нэг: мэдээлэгч үүрэг; хоёрт: танин мэдүүлж, соён гэгээрүүлэх үүрэг; гуравт: удирдлагын хэрэгсэл бологч үүрэг; дөрөвт: зохион байгуулагч үүрэг; тавд: хүмүүжүүлэгч үүрэг; зургаад: нийгэм, иргэдийг холбогч харилцааны үүрэг; долоод: зугаацуулан цэнгүүлэгч үүрэг болно.

Сэтгүүл зүйн шинжлэх ухаан өөрийн үндсэн зургаан зарчим, түүнээс үүдэн гарсан үндсэн долоон үүргээ биелүүлэх явцдаа ямагт чөлөөт байдлын төлөө тэмүүлж байдаг. Өөрөөр хэлбэл ард түмний хараа хяналтад төр засаг,

нийгмийг бүхэлд нь байлгаж “дөрөв дэх засаглал”-ын үүрэг гүйцэтгэхийг цаг ямагт эрмэлзэж байдаг гэсэн үг юм.

Ямар нэгэн хэвлэл чөлөөтэй байж чадаж байна уу, үгүй юу гэдгийг, тухайн улс оронд чөлөөт хэвлэлийн тогтолцоо байна уу, алга уу гэдгийг практик дээр хэмждэг цөөн шалгуур үзүүлэлт сэтгүүл зүйд байна. Энэ нь:

Нэгд: Улсын болон олон нийтийн, хувийн мэдээллийн хэрэгслийн зохист харьцаагаар; **хоёрт:** хэвлэл, мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд төр, засгийн зүгээс хяналт тавьж буй эсэхээр; **гуравт:** эдийн засаг, санхүүгийн хувьд тухайн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл хэн нэгнээс хараат байгаа эсэхээр; **дөрөвт:** хэвлэл мэдээллийн хэрэгсэлд төр засаг, улс төрийн намуудын удирдлага, нөлөө бүхий бизнесчид зэрэг нийгмийн дээд зиндааныхны серөг, алдаатай үйл ажиллагааг шударгаар шүүмжилж чадаж байна уу, үгүй юу гэдгээр; **五六т:** статусын хувьд бүрэн бие дааж чадсан эсэхээр; **зургаад:** сэтгүүлчдийн дотоод эрх чөлөөний байдлаар, өөрөөр хэлбэл чөлөөтэй сонголт хийж ямар нэгэн мэдээллийн хэрэгсэлд ажиллаж чадаж буй эсэхээр; **долоод:** уншигч, үзэгчид, сонсогчдын чөлөөт сонголтоор; **наймд:** ямар нэгэн улс төрийн бодлогоос ангид, улс төрийн намын харьялалгүй байдлаар; **есөд:** ил тод байдал, олон ургальч үзлийн индэр болж чадаж буй эсэхээр; **аравт:** хууль эрх зүйн хувьд чөлөөтэй, ямар ч хаалт, хязгаарлалтгүй байгаагаар; **арваннэгд:** төр, засгийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар “сөрөг хүчин”-ий үүргийг гүйцэтгэж чадаж буй эсэхээр тус тус хэмжиж үзэж болно.

Үүн дээр сэтгүүл зүйн үйл ажиллагааны арга хэлбэр, өвөрмөц онцлогууд, түүний үр нөлөө, үр ашгийн шалгуурын тухай тулгуур ойлголтыг нэмбэл сэтгүүл зүйн шинжлэх ухаан, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны үндсэн дүр төрх ерөнхийдөө тодрон харагдана.

Түүн дотор онцгойлж авч үздэг нэг зүйл бий. Энэ бол сэтгүүлчдийн ёс зүйн тухай ойлголт юм. Монголд хамгийн бүдэг бүрхэг байгаа зүйлийн нэг гэдгийг би үгийнхээ эхэнд цохон тэмдэглэсэн. Энэ нь цөөнгүй учир шалтгаантай.

Мэргэжил бүхэн өөрийн өвөрмөц онцлоготой. Тэрхүү онцлогоос үүдэн гарсан ёс зүйтэй. Эмч хүнд эмчийн ёс зүй гэж байна. Түүнийгээ тангараг өргөн илэрхийлж үйл ажиллагаандаа шударгаар мөрддөг.

Төрийн албан хаагчдад төрийн үйл ажиллагааны ёс зүй гэж байна. Тэр нь төрийн хар хайрцагны бодлогоор илрэн гарч, уламжлагдан өвлөгдөж, шинэчлэгдэн баяжигдаж байх жишээтэй. Сэтгүүлчдийн хувьд мөн ялгаагүй. Өөрийн гэсэн ёс зүйтэй. Сэтгүүлчид нь нийгэмд үйлчилнэ. Сэтгүүл зүйг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэгч хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол нийгмийн нэг чухал институт юм.

Монгол Улсын иргэн ямар эрх эдэлж, үүрэг хүлээнэ сэтгүүлч хүн яг адилхан. Харин сэтгүүл зүй нь бусад мэргэжлээс илүүтэйгээр нийгэмд үйлчилж, нийгмийн нэг чухал институт болж байдгийн хувьд сэтгүүлч хүн бусдаас илүү үүрэг хүлээнэ. Энэ нь тэдний ёс зүйгээр илүүтэйгээр илрэн гарч байдаг.

Сэтгүүлчийн ёс зүй гэдэг нь сэтгүүл зүйн шинжлэх ухааны үндсэн зарчим, үүргүүдтэй нягт холбоотой, түүнээс үүдэн гардаг гэдгийг би түрүүнд тэмдэглэж хэлсэн. Бүх улс түрүүдэд, олон улсын хэмжээнд ийм байдаг байна. Би энд зарим жишээг иш татаж ярья.

1923 онд америкийн сонины эрхлэгч нарын нийгэмлэгээс баталж эдүгээ ч хүчин төгөлдөр үйлчилж байгаа "Америкийн сэтгүүл зүйн ёс" хэмээх баримт бичигт:

"Уншигчид олж авахад чиглэсэн сонины үйл ажиллагаа гагцхүү нийгмийн сайн сайхны тухай санаа бодолд түшиглэнэ. Сонинд уншигчдын тавьж буй сонирхолд редакцийн хандах хандлага сэтгүүлчдийн хариуцлагын түвшинг тодорхойлж энэ хариуцлагыг редакцийн бүх ажилтан хүлээнэ. Сэтгүүлч амин хувийн зорилгодоо хүрэх буюу өөр зохисгүй санаа бодлоо хэрэгжүүлэхэд өөрийн чадварыг ашиглавал эрхэм үүрэгтээ шударга бус хандаж буй хэрэг юм" гэж онцлон тэмдэглэжээ. Цааш нь

Хараат биш байдал. Сонин нийгмийн өмнө хүлээх үүргээс бусад бүх үүргээс хараат биш байна. Сонины хувьд нийгмийн сонирхол эн тэргүүний ач холбогдолтой юм.

1. Сэтгүүлч ямар ч шалтаг заалаа гэсэн аливаа хувийн ашиг сонирхлыг дэмжих нь нийгмийн сайн сайхан байдалд хохирол учруулах бөгөөд шударга сэтгүүл зүйн зарчимтай нийцэшгүй юм. Хувийн эх сурвалж гэгчээс авах мэдээ нь уг сурвалж задрахгүй буюу энэ мэдээ хэлбэрээрээ ч, агуулгаараа ч бодит байдалд нийцнэ гэсэн өөр нотолгоогүй бол түүнийг мэдээлэхээ болино.

2. Үнэнийг нуусан редакцийн тайлбар зориуд бичих нь америкийн сэтгүүл зүйн эрхэм үнэт зүйлст харшлах бөгөөд харин хуурамч мэдээ нийтлүүлэх нь манай мэргэжлийн үндсэн зарчмыг зөрчсөн хэрэг болно гэж бичжээ.

"Америкийн сэтгүүл зүйн ёс" хэмээх баримт бичгийн

Шударга, үнэн зөв, нарийн тодорхой байх нь: хэмээх хэсэгт Уншигчид шударга хандах нь зориулалтдаа дүйсэн сэтгүүл зүйн үндэс юм.

1. Энэ нь юуны өмнө сонин үнэ зөв бичих ёстой гэсэн үг. Хайнга хандсан, эсвэл нарийн хянаж чадаагүй, нэг бол энэ талаар зохих захирамж аваагүй гэдгээр шалтаглавч сониниг училж таарахгүй, яагаад гэвэл энд сонины нийтлэл чанараа алдсан байх юм.

2. Гарчиг нь өгүүллийнхээ агуулгыг яг илэрхийлэх ёстой.

Шударга байх нь гэсэн нэг бүлэгт Сонин нь хүний нэр хүнд юм юмуу, ёс суртахууны нэр төрд хохирол учруулсан албан ёсны бус хүмүүсийн санаа бодлыг урьдаар тэр хүнд нь танилцуулалгүй нийтлэх ёсгүй, шүүхийн ажиллагааны тохиолдлоос бусад бүх тохиолдолд цаг ямагт тийм боломжийг тухайн хүнд олгох ёстой.

1. Иргэдийн хувийн амьдралд оролцох нь бэртэгчин байдлаар шохоорхох биш, харин чухал мэдээ олж авах нийгмийн хууль ёсны эрхтэй холбоотой гэдэгт итгээгүй цагт сонин тэгж оролцох ёсгүй.

2. Аливаа ноцтой алдаа, тэгэхдээ эдгээр алдаа баримтыг юмуу санаа бодлыг хамаарсан түүний эх сурвалж ямар байснаас үл шалтгаалан цаг тухайд нь бүрэн гүйцэд няцаалт хийж байх нь сонины эрх үүрэг мөн гэжээ.

Аятай зохистой байх гэсэн хэсэгт Сонин ёс суртахууны эрхэм дээд эрмэлзэлд үнэнч байна гэж мэдэгдэвч өөрийн үйлдэлдээ огт эсрэг жишээ үзүүлж, гэмт хэрэг үйлдсэн байдлыг нарийн ширийн гаргах буюу гэм согогийг дүрслэн үзүүлбэл нийгэмд огт ашиг тус өгөхгүй учраас тийм нөхцөлд сониныг үнэн сэтгэлээс хандаагүй гэж зэмлэж болно гэсэн байна.

Сэтгүүл зүйн ийм нийтлэг ёс зүй ганц Америкт ч биш соёл иргэншил өндөр хөгжсөн бүх улс оронд байдаг байна. Тэдгээрийг харьцуулан жишиж үзэхэд ардчилсан ихэнх улсынх адил төстэйг амархан олж харж болно.

Үүнийг нь олон улсын хэмжээнд баталгаажуулсан баримт бичиг ч бас байдаг байна.

“Сэтгүүлчдийн баримтлах зарчим” хэмээн нэрлэгдсэн Олон улсын сэтгүүлчдийн холбооны тунхаглалд:

1. Үнэнийг эрхэмлэж, үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрхийг хүндэтгэх нь сэтгүүлч хүний нэн тэргүүний үүрэг мөн.

2. Энэ үүргээ биелүүлэхдээ сэтгүүлч мэдэх сэлтийг зүй зохисынх нь дагуу цуглуулж, хэвлэн нийтлэх эрх чөлөө, шударгаар хэлж шүүмжлэх эрхийн зарчмуудыг цаг ямагт хамгаалах

3. Сэтгүүлч цаад эх сурвалжаар нь мэдэх зөвхөн тийм баримтуудад тулгуурлан бичиж мэдэлж байх. Сэтгүүлч чухал мэдээг нуун дараах юм уу баримт сэлтийг мушгин гүйвуулж болохгүй.

4. Шинэ сэргэг мэдээ, гэрэл зураг, баримт мэтийг олж авахдаа сэтгүүлч гагцхүү шударга аргыг хэрэглэх учиртай.

5. Аль нэг хэвлэгдсэн зүйл хор уршиг тарихуйц хуудуудтай болох нь нотлогдвол түүнийг засч залруулахын тулд сэтгүүлч бололцоотой бүхнийг хийнэ.

6. Итгэл хүлээж олж авсан мэдээллийн уг сурвалжтай холбогдох мэргэжлийн нууцыг сэтгүүлч хадгалж байх

7. Мэдээллийн хэрэгслээр дэвэргэсэн ялгаварлан гадуурхалт ямар аюултайг сэтгүүлч хүн ухамсарлаж, улмаар арьсны өнгө, хүйсний ялгаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн юмуу өөр үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарлаар болон бас бус шалтгаанаар ялгаж гадуурхахаас сээрэмжлэхийн төлөө чадах бүхнийг хийх.

8. Дараахь зүйлийг сэтгүүлч мэргэжлийн ноцтой алдаанд тооцно.

- Бусдын бүтээлийг хулгайлах

- Юмыг санаатайгаар мушгин гүйвуулах

- Бусдыг гутгэх, нэр төрийг нь гутаах, элдвийн нэр хоч өгч доромжлох, хүнийг ул үндэсгүй буруутгах

- Юмыг нийтэд мэдээлэх эсэхийг шийдэхдээ ямарваа нэг хэлбэрээр хүнийг ул үндэсгүй буруутгах

- Юмыг нийтэд мэдээлэх эсэхийг шийдэхдээ ямарваа нэг хэлбэрээр хээл хахууль авах

9. Сэтгүүлчид эрхэм нэр төрдөө эзэн болж, дээрх зарчмуудыг ёсчлон биелүүлэхийг өөрсдийн үүрэг гэж үзвэл зохино.

Тухайн улс орны хуулийн хүрээнд сэтгүүлчид үзэг нэгт нөхдийнхөө асуудлыг зөвхөн мэргэжлийн үүднээс шүүн хэлэлцэхийг хүлээн зөвшөөрнө.

Засгийн газар болон бусад эрх мэдэлтэн хөндлөнгөөс оролцох явдал байж болшгүй" гэж тэмдэглэсэн байна. /Брюссельд төвтэй Олон Улсын сэтгүүлчдийн холбооны 1954 оны Их хурлаас баталж, 1986 оны Их Хурлаас шинэчлэн засварлав гэжээ/

Прагад төвтэй Олон улсын сэтгүүлчдийн өөр нэг байгууллага бас байдаг бөгөөд тэд ч мөн иймэрхүү ёс зүйн зарчимтай байсныг тэмдэглэе.

Үүнээс үзэхэд АНУ-д, олон улсын сэтгүүл зүйн тогтсон хэм хэмжээнд ч сэтгүүчлийн ёс зүй гэсэн нэг нийтлэг ойлголт, нэгдмэл санаа бодол төлөвшин тогтсон нь тодорхой харагдаж байна.

Энэ бүгдийг иш үндэс болгож Монголын сэтгүүлчид мөн ёс зүйн зарчмаа баримт бичиг болгон баталгаажуулах оролдлогыг наяд оноос хийж эхэлжээ. Эхнийх нь нэг намын тогтолцооны үеийн ёс зүй учраас учир дутагдалтай байсан нь бүрэн ойлгомжтой билээ. Харин ардчилал өрнөсөн ерээд онд ахин нэг баримт бичиг гаргасан байна. Тэр нь: "Монголын сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн зарчим" гэсэн нэртэй бөгөөд уг баримт бичигт 11 зүйлийг эрхэмлэн хөндсөн байна.

Үнэнч шударга байх нь мэргэжлийн сэтгүүлчийн үүрэг

Үнэний төлөө зүтгэх нь мэргэжлийн сэтгүүлчийн зорилго гэсэн лидийн дор:

1. Үнэнийг эрхэмлэж, үнэнийг дээдлэх нь олон түмний эрхийг хүндэтгэх сэтгүүлчийн нэн тэргүүний үүрэг мөн.

2. Энэ үүргээ биелүүлэхдээ сэтгүүлч мэдээ мэдээллийг зүй зохисын дагуу цуглуулж, хэвлэн нийтлэх эрх чөлөөний зарчмыг шударгаар баримтална.

3. Сэтгүүлч зөвхөн уг эх сурвалжаар нь мэдэх баримтад тулгуурлан бичиж мэдээлж байх. Сэтгүүлчин чухал мэдээг нуун дараах юмуу, баримтыг мушгин гүйвуулж болохгүй.

4. Шинэ сэргэг мэдээ, гэрэл зураг, баримт сэлтийг олж авахдаа сэтгүүлч гагцхүү шударга аргыг хэрэглэнэ.

5. Мэдээ бодит биш нь нотлогдвол түүнийг засч залруулахын тулд сэтгүүлч бололцоотой бүхнийг хийнэ.

6. Итгэл хүлээж олж авсан мэдээллийн сурвалжтай холбогдох мэргэжлийн нууцыг сэтгүүлч чандлан хадгална.

7. Мэдээллийн хэрэгслээр арьсны өнгө, хүйсны ялгаа, хэл, шашин шүтпэг, улс төрийн өөр үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал зэргээр гадуурхахаас ямагт сээрэмжилнэ.

8. Дараах зүйлийг сэтгүүлч мэргэжлийн ноцтой алдаанд тооцно. Үүнд:

- Бусдын бүтээлийг хулгайлах
- Юмыг санаатайгаар мушгин гүйвуулах
- Бусдыг гүтгэх, нэр төрийг нь гутаах, нэр хоч өгч доромжлох, хүнийг ул үндэсгүй буруутгах,
- Юмыг нийтэд мэдээлэх эсэхийг шийдэхдээ ямарваа нэг хэлбэрээр хээл хахууль авах

9. Үндэснийхээ уламжлал, ёс заншлыг уран бүтээлдээ ёсчлон дагана.

10. Сэтгүүлчид эрхэм нэр төрдөө эзэн болж, дээрх зарчмуудыг ёсчлон биелүүлэхийг өөрсдийн үүрэг гэж үзнэ.

10. Мэргэжлийнхээ асуудлаар зөвхөн мэргэжил нэгт нөхдийнхөө шүүхийг хүлээн зөвшөөрнө" гэсэн байна.

Энд тэмдэглэсэн бүхэн нь АНУ, ялангуяа олон улсын сэтгүүлчдийн байгууллагын ёс зүйн зарчмаас төдийлэн ялгарах юмгүй гэж хэлж болно. Магадгүй энэ нь ч илүү дээр байсан байж мэднэ. Сэтгүүлчид нь олон улсын хэмжээнд адил төстэй түгээмэл үйл ажиллагаа явуулдаг өвөрмөц мэргэжилтэй хүмүүс юм. Тийм болохоор ёс зүй нь ижилэвтэр байж болох бүрэн үндэстэй.

Харамсалтай нь Монголд дээрх зарчмыг сэтгүүлчдийн ихэнх нь мэддэггүй бөгөөд .нилээд нь олж уншаагүй байж ч магадгүй. Мэддэггүй болохоор хэрэгжүүлэх тухай ярих нь илүүц зүйл. Үүнийг би сэтгүүлчдийн байгууллагуудын нэгдмэл үйл ажиллагаа үгүйтэй холбон ойлгож байна.

Ёс зүй гэдэг бол хүнлэг энэрэнгүй байх, үнэн бодитой байх, нийтлэл нэвтрүүлэг нь шинжлэх ухааны үндэстэй байх зэрэг сэтгүүл зүйн үндсэн зарчмуудаас урган гарч ирдэг бөгөөд тухайн сэтгүүлчийн хүнлэг байдал, мэдлэг чадварын илэрхийлэл болж байдаг билээ. Ёс зүйгүй юм бүхэн муухай бөгөөд гутамшигтай байдаг. Монголын сэтгүүл зүйн гол тогоо сүүлийн арван жилд сүрхий бузартаж булингартсан нь цөөнгүй сэтгүүлч ёс зүй гэдэг эрхэм ойлголтоо умартсаны харгай мөн бөгөөд бас бидний эгнээнд сэтгүүлч бус мэргэжлийн олон хүн орж ирсэнтэй ч холбоотой байж мэдэх юм. Хэдийгээр байдал ийм байгаа ч бүх зүйлийг хараар будаж болохгүй. Ёс зүйгээ чанд баримталж ажилладаг олон сэтгүүлч байгааг үгүйсгэж болохгүй.

Зарим хэвлэл мэдээллийн газрууд өөрсдийн үйл ажиллагааны өвөрмөц онцлогт нийцүүлж үйл ажиллагааны зарчим, ёс зүйгээ тодорхойлох нь ч үзэгдэж байна. Жишээ нь 2000 онд мэдээллийн МОНЦАМЭ агентлаг өөрийн "Алтан дүрэм"-тэй болж түүндээ 9 зүйлийг тунхаглажээ. Энэ нь энд ажиллагч сэтгүүлчид, уран бүтээлч ажилтнуудын нэг ёсны ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээ гэж хэлж болно. Үүнийг сонирхвол:

Нэг. Шуурхай, хамгийн шуурхай, бүхнээс шуурхай

*Хоёр. Төвчхон, аль болох төвчхон, бүр төвчхон
Гурав. Үнэн, бодит үнэн, гагцхүү үнэн*

*Дөрөв. Баталгаатай эх сурвалжтай, баримт нотолгоотой
Тав. Гарчиг содон, лид оновчтой, сэдэв шинэлэг*

*Зургаа. Хэл хэллэг чихнээ чимэгтэй, нүднээ тусгалтай
Долоо. Дүр дүрслэл яруу бөгөөд уран*

Найм. Утга санаа тодорхой, тов тодорхой

Ес. Ойлгомжтой, ой тойнд шингэж үлдэхүйц цэгцтэй гэжээ.

Энэ мэтээр хэвлэл, мэдээллийн нэг бус байгууллага, манай сэтгүүлчдийн олонхи нь өндөр ёс суртахуунтай, ёс зүйтэй байхыг хүсэн эрмэлзэж байна. Энэ бол зүй ёсны асуудал бизээ. Соёлтой нийгэмд соёлтой, хариуцлагатай сэтгүүл зүй үйлчлэх учиртай билээ.

Миний бие энд хоёр зүйлийг онцлон тэмдэглэхийг хүсч байна.

Нэгдүгээрт: Улс орон бүрт сэтгүүлчдийн ёс зүйн нийтлэг зарчим байдаг, олонхи сэтгүүлчид түүнийг практикт мөрдөж байдаг ч, амьдралд илүүтэй хэрэгждэг нь тухайн байгууллагын, өөрөөр хэлбэл сонин, сэтгүүл, радио, телевиз, мэдээллийн агентлагийн өөрийнх нь баримталдаг ёс зүйн зарчим юм байна гэж хэлмээр байна. Өнөөдөр Монгол Улсын мэдээллийн МОНЦАМЭ агентлагт “Алтан дүрэм” үйл ажиллагааных нь үндсэн зарчим, ёс зүйн хэм хэмжээ болж чадаж байгаа явдал үүнийг тодорхой харуулж байна.

Хоёрдугаарт: Сэтгүүлчийн ёс зүйн тухай ойлголт түүний онол, практикийн үндэслэл, амьдрал практикт зайлшгүй хэрэгтэй гэдгийг их, дээд сургуулийн сэтгүүл зүйн ангийн сургалтаар түлхүү ухааруулах нь зүйтэй юм гэсэн саналтай байна.

Энэ чиглэлээр оюутнуудад өгч буй мэдээ мэдээллийг би хувьдаа хангалтгүй гэж үзэж байна. МУИС-д ёс зүйн сэдвээр ямар нэгэн хэлбэрээр сургалт явуулж буй нь үнэн боловч хувийн их, дээд сургуулиудийн сэтгүүл зүйн ангид энэ сэдэв бараг бүрмөсөн орхигдсон гэж хэлэхэд нэг их хилсдүүлэл болохгүй болов уу.

Ёс зүйгээр дагнаж дадлагажсан эрдэмтэн багш нар ч бараг алга байна. Энэ бол санаа зовмоор зүйлийн нэг яриангүй мөн бөгөөд хичнээн эрдэмтэй ч бай ёс зүйгүй сэтгүүлчдийг бэлтгэн гаргах нь хатуухан хэлэхэд бараг гэмт хэрэг юм шүү гэж анхааруулмаар байна.